

## Хувилбар В

## Нэгдүгээр хэсэг

1. Монгол орны томоохон талуудын нэг болох Тамсагийн тал ямар гарал үүсэлтэй вэ? /1 оноо/  
 А. хуримтлалын В. нуурын С. аллювийн D. делювийн Е. морены

2. 1921 оны өмнөх засаг захиргааны хуваарийг харуулсан дараах зурагт 4-ын тоогоор ямар аймгийг тэмдэглэсэн байна вэ? /1 оноо/



A. Засагт хан аймаг  
 D. Сэцэн хан аймаг

B. Сайн ноён хан аймаг  
 E. Ховдын хязгаар

C. Түшээт хан аймаг

3. Тэгш хэвтээ байрлалтай чулуулгийн үе давхаргууд тектоник хөдөлгөөний нөлөөгөөр цуурч зөрдөг. Зөрж доош суусан хэсгийг юу гэдэг вэ? /1 оноо/

A. Горст В. Антиклиналь С. Грабен D. Синклиналь Е. Геосинклиналь

4. Дараах химийн нэгдлүүдээс аль нь фотосинтезийн үйл явцад оролцдог вэ? /1 оноо/

A. H<sub>2</sub>O В. NaF С. SO<sub>2</sub> D. NO<sub>3</sub> Е. C<sub>8</sub>H<sub>18</sub>

5. Цэгийн оронд тохирох үгийг сонгоно уу? /1 оноо/

.....голдоч гэнэ.

- A. Анхны голдчоос тухайн цэг хүртэлх зэргэдийн нумын өнцгийг  
 B. Экватороос тодорхой цэгт орших цэгийн нумын градусыг  
 C. Экватортой зэрэгцээ татсан шугамыг  
 D. Хоёр туйлыг холбосон гадарга дээрх шугамыг  
 E. Дэлхийн төвийг дайруулан татсан шугамыг

6. Дараах бүдүүвчийн асуултын тэмдгийн оронд тохирох үг юу вэ? /1 оноо/



A. Хүмүүн капитал  
 D. Хүн амын цонх үе

B. Ажилгүйчүүд  
 E. Ажиллагсад

C. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин

7. Түүх, хэл, соёл, сэтгэлгээ амьдрал ахуйн хувьд бие биетэйгээ ойр төрөл, нэгэн угсаа гаралтай хүмүүсийг.....гэнэ. /1 оноо/

A. үндэстэн В. угсаатны нийтлэг С. омог D. ястан Е. түрэг хэлтэн

8. Цаг агаарын нөхцлөөс тэр бүр шалтгаалахгүй, тогтмол үйл ажиллагаатай, их хэмжээний ачаа, олон тооны зорчигчийг тээвэрлэх боломжтой зэргээр бусад тээврээс ялгаатай тээврийн төрөл юу вэ? /1 оноо/  
 А. Авто замын тээвэр                      В. Агаарын тээвэр                      С. Төмөр замын тээвэр  
 D. Усан замын тээвэр                      E. Дамжуулах хоолойн тээвэр

9. Монгол орны Газарзүйн шинжлэх ухааны нэрт эрдэмтэн О.Намнандоржийн судалгааны чиглэл, голлох бүтээл юу вэ? /1 оноо/  
 А. Физик газарзүй, Монгол орны физик газарзүй  
 В. Нийгэм эдийн засгийн газарзүй, БНМАУ-ын нийгэм эдийн засгийн газарзүй  
 С. Мал аж ахуйн газарзүй, Бэлчээрийн мал аж ахуйн газарзүй  
 D. Ус зүй, палеонтологи, Монгол орны агуй, рашаан  
 E. Ландшафт судлал, Дорнод Хангайн структур геоморфологийн онцлог

10. Дараах зурагт 4-ын тоогоор юуг тэмдэглэсэн байна вэ? /1 оноо/




- А. Бискайн булан                      В. Мексикийн булан                      С. Мадагаскар арал  
 D. Камчаткийн хойг                      E. Аляскийн хойг

11. Дараах хариултуудад шинэхэн цас, элс, ой мод, хар шорооны альбедо болон дэлхийн нийт альбедог өгчээ. Аль нь элсний альбедо вэ? /1 оноо/

- А. 25                      В. 8                      С. 30                      D. 85                      E. 4

12. Дараах зурагт Монгол орны төв цэг оршдог аймгийг хэдийн тоогоор тэмдэглэсэн байна вэ? /1 оноо/



- А. 1                      В. 4                      С. 2                      D. 3                      E. 5

13. Номхон далайн хамгийн гүн хонхор аль нь вэ? /1 оноо/

- A. Марианы хонхор /11022 м гүн/
- B. Пуэрто-Рико /8742 м гүн/
- C. Зондын хонхор /7729 м гүн/
- D. Гренландын тэнгис /5527 м гүн/
- E. Сөнөсөн тэнгис /395 м гүн/

14. Төв аймгийн Баяндэлгэр сумын нутагт орших.....орд нь 600 сая.тн хүрэн нүүрсний нөөцтэй. /1оноо/

- A. Шивээ-Овоо
- B. Тавантолгой
- C. Багануур
- D. Шарын гол
- E. Зүүнбаян

15. Зурагт 4-ийн тоогоор тэмдэглэсэн аймаг эдийн засгийн ямар бүсэд багтах вэ? /1 оноо/



- A. Баруун
- B. Зүүн
- C. Хангайн
- D. Төвийн
- E. Улаанбаатарын

16. Монгол улс болон ОХУ-ын хиллэх шугамын урт хэд вэ? /1 оноо/

- A. 3485 км
- B. 4676,9 км
- C. 2392 км
- D. 1259 км
- E. 5145 км

17. Дараах корпорациудаас аль нь үндэстэн дамнасан корпораци вэ? /2 оноо/

- A. Mobicom
- B. Tavanbogd
- C. MGL
- D. Mogul
- E. Toyota

18. Цилиндр тусгагийн өргөрөг нь шулуун, уртраг нь..... хэлбэртэй байдаг. /2 оноо/

- A. тойрог
- B. шулуун
- C. нэг цэгээс цацарсан шулуун
- D. дөрвөлжин
- E. бөөрөнхий


19. Зэрлэг нохой дингог харах сонирхолтой хүн ямар улсад очих нь зөв бэ? /2 оноо/

- A. Словек
- B. Лесото
- C. Молдав
- D. Австрали
- E. Кени

20. Агаарын даралтыг хэмжих бол аль багажийг ашиглах вэ? /2 оноо/


- A. Термометр
- B. Барометр
- C. Гигрометр
- D. Флюгер
- E. Луужин

21. Дараах зургийг ажиглаад асуултын тэмдгийн оронд тохирох хариултыг сонгоно уу? /2 оноо/



- A. 157000000 км
- B. 7-р сарын 15
- C. Хаврын өдөр шөнийн тэнцэл
- D. Намрын өдөр шөнийн тэнцэл
- E. 7-р сарын 5

22. Дараах зурагт Монгол орны байгалийн ямар бүсийг үзүүлсэн бэ? /2 оноо/



- A. Хээрийн бүс
- B. Цөлийн бүс
- C. Говийн бүс
- D. Ойт-хээрийн бүс
- E. Уулын босоо бүслүүр

23. Газар хөдлөлт анх эхэлсэн газрын гүн дэх хэсгийг юу гэж нэрлэдэг вэ? /2 оноо/

- A. Дотоод голомт буюу төв
- B. Гадаад голомт буюу эпицентр
- C. Дотоод голомт буюу эпицентр
- D. Гадаад голомт буюу төв
- E. Газар хөдлөлтийн идэвхитэй бүс

24. Эх газрын байрлалтай улсууд аль нь вэ? /2 оноо/

- A. Иран, Ирак
- B. Солонгос, Энэтхэг
- C. Малайз, Филиппин
- D. Шри-Ланк, Индонез
- E. Нигер, Казакстан


25. Нутаг дэвсгэрийн хэмжээгээрээ 2, 4-р байрт ордог аймгууд аль нь вэ? /2 оноо/

- A. Говь-Алтай, Баянхонгор
- B. Дорноговь, Сүхбаатар
- C. Өвөрхангай, Хэнтий
- D. Завхан, Ховд
- E. Өмнөговь, Дорнод

26. Улаанбаатар хотын нэрний өөрчлөлтийг хугацаатай нь зөв тохируулан бичсэн хариултыг сонгоно уу? /2 оноо/

- A. 1639 оноос Богдын өргөө
- B. 1911 оноос Нийслэл хүрээ
- C. 1940 оноос Улаанбаатар
- D. 1639 оноос Да хүрээ
- E. 1911 оноос Номын хүрээ

27. Монгол улсын одоогийн засаг захиргааны нэгжийг зөв гүйцээх үг юу вэ? /2 оноо/




- A. Дүүрэг, Хороо
- B. Сум, Баг
- C. Баг, Хороо
- D. Дүүрэг, Сум
- E. Сум, Хороо

28. Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 5-аас дээш хувийг үйлдвэрлэж байгаа болон үйлдвэрлэх боломжтой ордуудыг стратегийн орд гэнэ. Тэгвэл дараах ордуудаас аль нь стратегийн ач холбогдол бүхий орд вэ? /2 оноо/

- A. Говь-Алтай аймаг - Зээгтийн нүүрсний орд
- B. Дорнод аймаг – Адуунчулууны нүүрсний орд
- C. Баян-Өлгий аймаг – Асгатын мөнгөний орд
- D. Хөвсгөл аймаг - Эгийн голын нүүрсний орд
- E. Увс аймаг - Хар тарвагатайн нүүрсний орд

29. Дараах зурагт 1 ба 2-ын тооны оронд бичигдэх төмөр замын өртөөний нэр юу вэ? /2 оноо/



- A. 1-Ерөө, 2- Бор-Өндөр
- B. 1-Сайншанд, 2- Даланзадгад
- C. 1-Багануур, 2-Баруун урт
- D. 1-Шарын гол, 2- Зүүнбаян
- E. 1-Багануур, 2- Шарын гол


30. Меринус үүлдрийн хонийг их үржүүлдэг Веллингтон хот Австралиас 1920 км зайтай оршдог. Энэ хот ямар улсын нийслэл вэ? /2 оноо/

- A. Бангладеш
- B. Эквадор
- C. Бразил
- D. Фижи
- E. Шинэ Зеланд

31. Сэлэнгэ аймагт 2010 оны байдлаар 48800 ажиллагсад, 1120 бүртгэлтэй ажилгүйчүүд байсан бол ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхитэй хүн амыг олно уу? /2 оноо/

- A. 1120
- B. 44000
- C. 48800
- D. 49920
- E. 45824

32. Шашны ангилалыг зөв нөхөж гүйцээх хариулт аль нь вэ? /2 оноо/



- A. Шарын, Бага хөлгөн,
- B. Шинто, Лам
- C. Күнз, Лал
- D. Үнэн алдартан, Католик
- E. Хинди, Бөө мөргөл

33. Зүүн Европын улсууд аль нь вэ? /2 оноо/

- A. Австри, Бельги, Швейцар
- B. Дани, Норвеги, Финлянд
- C. Грек, Итали, Португал
- D. Румын, Чех, Унгар
- E. Украин, Гүрж, Югослав

34. Ноолуур, ноосны чиглэлийн нутгийн шилмэл омгийн ямааны үүлдэр аль нь вэ? /2 оноо/

- A. Уулын бор, Өнжүүл, Уулын алтай
- B. Баяд, Чамаар, Орхон
- C. Сэлэнгэ, Хар тарлан, Сементаль
- D. Гал шар, Тэс
- E. Галбын говийн улаан, Хэцийн хүрэн, Хос зогдорт


35. 30,3 км<sup>2</sup> сая талбайтай бөгөөд экваторын шугам нутаг дэвсгэрийн яг дундуур, анхны голдоч эх газрын баруун захаар дайран өнгөрдөг. Энэ тивийн хойд захын цэг Бен-Секка хошуу х.ө 38°, урд захын цэг Иголийн хошуу ө.ө 35°-т оршдог, ойролцоогоор 900 сая хүн амтай. Энэ ямар тив бэ? /2 оноо/

- A. Ази
- B. Америк
- C. Африк
- D. Австрали
- E. Европ

36. Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээ 1564116 км<sup>2</sup> ба 2010 онд 2700000 хүн амтай байсан бол хүн амын нягтшилыг олно уу? /2 оноо/

- A. 1,3
- B. 0,4
- C. 1,5
- D. 1,7
- E. 2,1

37. Дараах зурагт 2-ын тоогоор тэмдэглэсэн гадаргын усны ай савын үзүүлэлт аль нь вэ? /2 оноо/



- A. Нийт нутаг дэвсгэрийн -20%, урсацын-15%
- B. Нийт нутаг дэвсгэрийн -20%, урсацын-50%
- C. Нийт нутаг дэвсгэрийн -60%, урсацын-31%
- D. Нийт нутаг дэвсгэрийн -80%, урсацын-5%
- E. Нийт нутаг дэвсгэрийн -90%, урсацын-10%

38. Дараах хүснэгтэд өгөгдсөн уур амьсгалын нөхцөл бүхий газар нутаг хаана байж болох вэ? /2 оноо/

	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар
Температур /°с/	10	12	16	20	23	24	25	24	23	20	15	11
Тунадас/ мм/	15	41	23	58	122	246	373	345	155	38	8	3


A. Антрактид      B. Сибир      C. Балба      D. Аляск      E. Шинэ газар арал

39. Дараах зурагт аль тивийн ямар улсын нутаг дэвсгэрийг дүрсэлсэн байна вэ? /2 оноо/



- A. Ази тив- Казакстан улс
- B. Европ тив- Их Британи улс
- C. Ази тив- Филиппин улс
- D. Европ тив- Швед улс
- E. Ази тив-Япон улс

40. Дараах зурагт 1 ба 2-ын тоогоор тэмдэглэсэн аймгуудын нэр болон цагийн бүсийн дугаарыг зөв харгалзуулсныг олоорой. /2 оноо/




- A. 1-Дундговь аймаг 8-р бүс, 2-Өмнөговь аймаг 6-р бүс
- B. 1-Говь-Алтай аймаг 6-р бүс, 2-Төв аймаг 8-р бүс
- C. 1-Сэлэнгэ аймаг 7-р бүс, 2-Баян-Өлгий 6-р бүс
- D. 1-Төв аймаг 7-р бүс, 2-Говь-Алтай аймаг 6-р бүс
- E. 1-Булган аймаг 8-р бүс, 2-Завхан аймаг 6-р бүс

41. Өөрийн тодорхой нэр, эзэмшил газар нутагтай, хэл, соёл, сэтгэл зүйн онцлог, зан заншил, уламжлалаар холбогдсон хүмүүсийн нийтлэгийг ястан гэдэг. 2000 оны байдлаар 66,7 мянга гаруй хүн амтай, Монгол улсын нийт хүн амын 2,8%-ийг эзэлдэг нэгэн ястанг дараах зурагт харуулжээ. Энэ ямар ястан байна вэ? /2 оноо/

- A. Дарьганга
- B. Үзэмчин
- C. Дөрвөд
- D. Хотгойд
- E. Сартуул



42. Дэлхийд ховор, манай улсад нэн ховор болсон Хулан хойрго нь байгалийн аль бүсэд ургадаг вэ? /2 оноо/



- A. Говь-цөлийн бүс
- B. Хээрийн бүс
- C. Ойт хээрийн бүс
- D. Ойн бүс
- E. Тайгын бүслүүр

43. Аравын хойг, Африкаас жилд дунджаар 30 мм-ээр холдож байгаа гэж үзвэл 700000 жилийн дараа хоорондын зай нь одоогийнхоос хэдэн км холдох вэ? /2 оноо/

- A. 210000 км
- B. 210 км
- C. 21000 км
- D. 21 км
- E. 2100 км

44. Байгалийн бүс бүслүүр тус бүрт тархах хөрсний хэв шинжийг зөв тохируулан сонгоно уу? /2 оноо/

Байгалийн бүс бүслүүр	Хөрсний хэв шинж
1. Саванн	а. Хар шороон
2. Сэрүүн бүсийн хээр	б. Чандруулаг
3. Тайга	в. Улаан хүрэн

- A. 1в, 2б, 3а
- B. 1а, 2б, 3в
- C. 1в, 2а, 3б
- D. 1б, 2а, 3в
- E. 1б, 2в, 3а

45. Дараах уул нуруудыг зүүнээс баруун тийш нь зөв дараалуулсан нь аль нь вэ? /2 оноо/

- A. Байтаг богд, Түргэн, Шүдэн
- B. Лхачинвандад, Хөгнө хан, Цамбагарав
- C. Мөнхсарьдаг, Булнайн нуруу, Ээж хайрхан
- D. Бүтээлийн нуруу, Хөрх, Түргэн
- E. Таванбогд, Тарвагатайн нуруу, Асралт хайрхан


46. Дараах гол мөрдийг цутгах нууртай нь зөв харгалзуулна уу? /2 оноо/

- 1. Тэс
- 2. Чоно харайх
- 3. Хэрлэн
- а. Далай нуур
- б. Увс нуур
- в. Хар нуур

- A. 1а, 2б, 3в
- B. 1б, 2в, 3а
- C. 1в, 2б, 3а
- D. 1а, 2в, 3б
- E. 1в, 2а, 3б




47. Дараах зурагт үзүүлснээр Б-ээс А-рүү очсон жуулчин байгалийн ямар бүсээс ямар бүсэд очсон вэ? /2 оноо/



- A. Экваторын ойн бүсээс хагас цөлийн бүсэд
- B. Цөлийн ба хагас цөлийн бүсээс экваторын чийглэг ойн бүсэд
- C. Халуун орны хээрээс өндөр уулын бүсэд
- D. Хээрийн бүсээс цөлийн бүсэд
- E. Цөлийн бүсээс өндөр уулын бүсэд

48. Газрын гадаргын хэлбэр дүрс нь дотоод, гадаад олон хүчин зүйлүүдийн үйлчлэлээр үүсдэг. Дараах зурагт үзүүлсэн гадаргын хэлбэр ямар хүчин зүйлийн үйлчлэлээр үүссэн бэ? /2 оноо/



- A. Мөсөн гол
- B. Галт уул
- C. Гол мөрөн
- D. Түр зуурын урсгал ус
- E. Салхи

49. Тэнгисүүдийг орших далайтай нь тохируулна уу? /2 оноо/

- |                     |                      |
|---------------------|----------------------|
| 1. Номхон далай     | a. Андаманы тэнгис   |
| 2. Атлантын далай   | b. Баренцын тэнгис   |
| 3. Энэтхэгийн далай | c. Карибын тэнгис    |
| 4. Хойд мөсөн далай | d. Филиппиний тэнгис |

- A. 1d, 2c, 3a, 4b    B. 1c, 2b, 3a, 4d    C. 1b, 2d, 3c, 4a    D. 1a, 2d, 3b, 4c    E. 1b, 2a, 3d, 4c

50. Ангараг гарагийн нарнаас алслагдах зайг о.о.н ээр илэрхийлнэ үү? /2 оноо/

- A. 1    B. 0,72    C. 29,94    D. 5,18    E. 1,52

**Хоёрдугаар хэсэг.  
Тооцоолох даалгавар**

**Санамж:** Хоёрдугаар хэсэг нь тус бүр 4 оноотой 4 даалгавраас бүрдэнэ. Даалгаврын хариуг хариултын хуудасны хоёрдугаар хэсэгт дараах байдлаар бөглөхийг анхаарна уу?

Жишээлбэл: Эцсийн хариу 5482 гэж гарсан бол a-5, b-4, c-8, d-2 гэж бөглөнө.

2.1. Монгол орны өмнөд захын цэг болох Орвог Гашууны бор толгойгоос хойд туйлын цагираг хүртэл шулуун зайгаар хэдэн км байх вэ?

2.2. 1 см-т 2 км нэрлэсэн масштабтай зураг дээр хоёр хотын хоорондын зай 15 см зурагдсан бол 1 см-т 1,5 км нэрлэсэн масштабтай зураг дээр хэдэн см зурагдах вэ?

2.3. Жижиг автобус 8-р сарын 30-ны өдөр 30 зорчигчтой Улаанбаатар хотоос хөдөлсөн ба нийт 1023 км зам туулж Завхан аймагт очив. Зорчигч тээврийн эргэлт хэдэн хүн.км болохыг бодож олно уу?

2.4. Өргөргийн тойргийн урт 24576 км бол тухайн өргөрөг дээр орших газар нутгуудад дэлхийн тэнхлэгээ тойрон эргэх хөдөлгөөний улмаас үүсэх шугаман хурд хэдэн км/цаг байх вэ?

